



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Тарваган тахал өвчнөөс урьдчилан  
Сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 35.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлт заавар” А/160, А/161 дүгээр тушаал, 2018 оны “Халдварт өвчний зонхилон тохиолдлыг тандах журам батлах тухай” А/527 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Тарваган тахал болон хүн, малын гоц Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1051 дүгээр захирамж, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын А/172 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тарваган тахлын вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Тарваган тахал өвчний вакцинаар дархлаажуулах ажлыг товлосон хугацаанд Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлэхийг тархвар судлаач /О.Төртулга/-д үүрэг болгосугай.
3. Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг тархвар судлаач /Г.Халиунаа/, иргэдэд чиглэсэн зөвлөмж, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг сургалт хариуцсан мэргэжилтэн /Н.Отгонцацрал/-д даалгасугай.
4. Эмнэлгийн тусгаарлах өрөөний нэн шаардлагатай эм, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгслийн жагсаалт, тоог хэмжээг гаргаж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эм зүйн албаны дарга /Д.Эрдэнэцэцэг/-д даалгасугай.
5. ЭМТ-ийн тасаг нэгжийн дарга эрхлэгч нар болон ӨЭМТ-ийн дарга нарт даалгах нь:
  - 5.1 Голомтод дайчлан ажиллуулах мэргэжилтнүүдийн судалгааг гарган томилж, үүрэгжүүлэх,

3 170 7032000

5.2 Эмнэлгийн тусгаарлах өрөөний нэн шаардлагатай эм, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгслийн жагсаалт, тоо хэмжээг гаргаж, бэлэн байдлыг хангах,

5.3 Тарваган тахлын сэжигтэй өвчтөн ирсэн үед тусгаарлан, нарийн мэргэжлийн эмч нар оношийг тогтоож, өвчтөнийг эмнэлэг дамжуулан явуулахгүй байх,


5.4 Тарваган тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвд 30 минутаас 2 цагийн дотор яаралтай мэдээлж, эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг хийж, эрсдэлийн зэргийг тогтоон, гарааны арга хэмжээг авч, голомтын хариу арга хэмжээг үйл явдлын тэргүүлэгч байгууллагатай хамтран зохион байгуулах,

5.5 Хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг оношлох, мэдээлэх, өвчтөнөөс лабораторийн сорьц авах, савлах, тээвэрлэх, тархвар судлал, тандалтын хариу арга хэмжээ авах талаар эмч, мэргэжилтнүүдийг сургах,

5.6 Нийт хүн ам болон эрсдэлт бүлгийн хүн амд тарваган тахал өвчнөөс сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг идэвхжүүлэн, зохион байгуулах,

5.7 Хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцын талаарх мэдээллийг баримтжуулан тус төвийн тархвар судлаач /Г.Халиунаа/-д [khaliunaag3@gmail.com](mailto:khaliunaag3@gmail.com) цахим хаягаар 2022 оны 09-р сарын 27-ны өдрийн дотор ирүүлэх,

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн Эрүүл мэндийн орлогч дарга /Б. Лувсанням/ -д даалгасугай.

ДАРГА  Э.БОДЬЦЭЦЭГ

ТТБ 2030 м 9120267

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын  
2022 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн  
А/63 -р тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Лувсанням	НЭМО дарга
Нарийн бичиг:	С.Өлзийжаргал	Тархвар судлаач
Гишүүд:	О.Төртулга	Тархвар судлаач
	Г.Халиунаа	Тархвар судлаач
	Н.Отгонцацрал	МСС хариуцсан мэргэжилтэн
	Б.Мөнхцэцэг	Дархлаажуулалтын сувилагч